



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/120

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "2019 оныг Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгох тухай" зарласан жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.5.4, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор батлагдсан "Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай" тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 тоот захирамжаар батлагдсан "2019 оныг Бүтээн байгуулалтыг нэмэгдүүлж, өрхийн аж ахуйг хөгжүүлэх жил болгон зарлах тухай" захирамжийн 1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Атрын 60 жилийн ойг угтаж, Нийгмийн хариуцлагын хүрээнд "100 га-д 1 ажлын байр" төслийг төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар шинээр ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Ж.Сайнцог

-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Б.Энхбат

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Болорзул

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Д.Ёндонжамц

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

А.Эрдэнэгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

О.Мөнхбаяр	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.Лувсандагва	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
Л.Зоригтбаатар	-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Б.Мөнхтөр	-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Б.Саруултөгс	-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
С.Отгонжаргал	-Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.Бүрэнжаргал	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн мэргэжилтэн
Б.Пүрэвсүрэн	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч /тохиролцсоноор/
Б.Ганболд	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч /тохиролцсоноор/ -17 сумдын Засаг дарга, тосгодын захирагч нар

2.Төслийг хэрэгжүүлэх ажлыг чанартай сайн зохион байгуулан, хяналт тавин биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн дарга, аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

